



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/62

Чингис хот

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Сариг багт улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лобароторийн шинжилгээний хариугаар мал амьтны гоц халдварт гахайн африкийн мялзан өвчин оношлогдсон бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 дугаар захирамжийн хүрээнд холбогдох зааврын дагуу арга хэмжээг авч ажилласны үр дүнд өвчлөл илрээгүй тул 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Тухайн суурьт эцсийн халдваргүйтгэл хийж ажиллахыг Абока мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Ж.Амгалан)-д даалгасугай.

3. Гахайн аж ахуй эрхэлж буй иргэдийг, Мал амьтны гоц халдварт Гахайн африкийн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Д.Сандагдорж)-д даалгасугай.

4. Хязгаарлалтын дэглэмийг цуцалсантай холбогдуулан Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР